**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/80/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Р.Аюуш<br>Утас: 70453799, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ........ 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13
    3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 13
    3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 13
    3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 14
    3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ........ 14
    3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 15
    3.5.1 Төсвийн төлөвлөлт ........ 15
    3.5.2 Төсвийн гүйцэтгэл ........ 15
    3.5.3 Нэмэлт төсөв ........ 16
    3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ........ 16
4. Аудитын тайлан ........ 16
    4.1 Ерөнхий зүйл ........ 16
    4.2 Материаллаг байдал ........ 17
    4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт ........ 17
    4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 17
    4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 17
    4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт ........ 18
    4 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 18
    4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 18
5. Аудитын илрүүлэлт ........ 18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ........ 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
213400. Увс аймаг. Улаангом сум.
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ ГАЗРЫН ДАРГА
А.БОЛОРМАА ТАНАА

2023.02.15 № УВА-2023/120/НА-СТА-ТИ13
танай______________-ны №__________________-т

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

## Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

0200500043

**Бусад асуудлын хэсэг**

Увс аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь "Чадварлаг багш" 2021-2024 хөтөлбөр хэрэгжүүлэн тайлант онд "Эрдэм шинжилгээний бага хурал", "Сайн хичээлийн зөвлөгөөн", "Багш солилцоо", "Зочин багш", "Зөвлөн туслах үйл", "Сайн хичээлийн зөвлөгөөн" зэрэг багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **14,252,520.80** | **11,693,895.20** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 13,579,945.20 | 11,693,895.20 |
| **354** | **Хангамжийн материал** | 13,579,945.20 | 11,693,895.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 715,000.00 | 231,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 260,900.00 | 170,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,604,045.20 | 11,291,995.20 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 672,575.60 | |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 672,575.60 | |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **573,481,610.31** | **577,575,288.40** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 573,841,610.31 | 577,575,288.40 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 528,381,610.31 | 532,475,288.40 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 466,216,884.00 | 466,216,884.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -36,495,295.52 | -48,317,839.52 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 89,430,000.00 | 89,430,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -61,118,889.02 | -69,830,000.10 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 135,031,122.20 | 158,221,432.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -84,236,630.98 | -83,158,542.65 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 48,749,039.80 | 48,745,412.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -38,156,320.17 | -37,186,707.73 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 9,000,740.00 | 8,820,340.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,749,740.00 | -3,176,390.00 |
| 39217 | Ном | 2,710,700.00 | 2,710,700.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 45,100,000.00 | 45,100,000.00 |
| 39301 | Програм хангамж | 535,000.00 | 150,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -535,000.00 | -150,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 45,100,000.00 | 45,100,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **587,734,131.11** | **589,269,183.60** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **587,734,131.11** | **589,269,183.60** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 587,734,131.11 | 589,269,183.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 612,287,721.25 | 612,287,721.25 |
| 51101 | Өмч: - төрийн | 612,287,721.25 | 612,287,721.25 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -244,465,581.11 | -242,531,688.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -244,465,581.11 | -244,066,740.90 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 1,535,052.49 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 219,911,990.97 | 219,513,150.76 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **587,734,131.11** | **589,269,183.60** |

20
УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 2,562,958,440.50 | 4,315,151,273.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 108,663,105.50 | 171,366,123.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 108,663,105.50 | 171,366,123.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 5,755,900.00 | 9,949,998.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 102,907,205.50 | 161,416,125.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 2,454,295,335.00 | 4,143,785,150.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,208,987,300.00 | 4,082,512,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,208,987,300.00 | 4,082,512,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 245,308,035.00 | 61,272,950.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,000,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 236,725,835.00 | 58,962,950.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,582,200.00 | 2,310,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 2,551,898,931.69 | 4,313,616,220.51 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,551,898,931.69 | 4,313,616,220.51 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 760,243,660.69 | 724,612,192.51 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 283,733,375.00 | 319,448,769.00 |
| 210101 | Үндсэн цалин | 159,566,930.00 | 203,722,635.00 |
| 210102 | Нэмэгдэл | 87,300,156.00 | 57,890,882.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,925,000.00 | 36,503,000.00 |
| 210104 | Урамшуулал | 13,941,289.00 | 21,332,252.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,267,451.00 | 39,470,752.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,364,706.84 | 27,153,156.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,817,234.10 | 3,194,487.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,253,947.48 | 2,555,590.12 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 529,996.32 | 592,561.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,301,566.26 | 5,974,956.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,830,506.00 | 44,670,603.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,791,682.00 | 2,892,449.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,876,704.00 | 40,470,144.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,162,120.00 | 1,308,010.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 155,112,320.05 | 196,962,299.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 15,961,725.00 | 8,841,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,991,570.00 | 19,058,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 689,538.00 | 627,929.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,395,300.00 | |

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 18,792,600.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,576,350.00 | 3,572,620.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 4,755,000.00 | 2,773,050.00 |
| 210409 | Бараа материал шилжүүлсэний зардал | 102,952,237.05 | 162,088,700.60 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,265,800.00 | 6,205,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 100,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 3,165,800.00 | 6,205,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,528,500.00 | 15,450,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,528,500.00 | 15,450,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,286,649.00 | 9,502,549.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,841,500.00 | 7,650,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 216,600.00 | 159,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 211,749.00 | 211,749.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 873,000.00 | 360,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 451,000.00 | 451,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 217,219,059.64 | 92,902,019.91 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 23,968,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 181,416,150.00 | 30,977,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 35,802,909.64 | 37,956,319.91 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,791,655,271.00 | 3,589,004,028.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,653,112,112.00 | 3,406,529,134.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 886,487,146.00 | 996,818,751.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 756,084,966.00 | 2,408,910,383.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,540,000.00 | 800,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 138,543,159.00 | 182,474,894.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 138,543,159.00 | 182,474,894.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | 11,059,508.81 | 1,535,052.49 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,254,666.60 | |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,254,666.60 | |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | 9,804,842.21 | 1,535,052.49 |

20
УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | 2,454,295,335.00 | 4,143,785,150.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 2,454,295,335.00 | 4,183,785,150.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,208,987,300.00 | 4,082,512,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,208,987,300.00 | 4,082,512,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 245,308,035.00 | 61,272,950.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,000,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 236,725,835.00 | 58,962,950.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,582,200.00 | 2,310,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | 2,413,615,335.00 | 4,111,685,150.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,413,615,335.00 | 4,111,685,150.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 621,960,064.00 | 522,681,122.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 282,733,375.00 | 319,448,769.00 |
| 210101 | Үндсэн цалин | 158,566,930.00 | 203,722,635.00 |
| 210102 | Нэмэгдэл | 87,300,156.00 | 57,890,882.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,925,000.00 | 36,503,000.00 |
| 210104 | Урамшуулал | 13,941,289.00 | 21,332,252.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,267,451.00 | 39,470,752.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,364,706.84 | 27,153,156.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,817,234.10 | 3,194,487.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,253,947.48 | 2,555,590.12 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 529,996.32 | 592,561.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,301,566.26 | 5,974,956.69 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,830,506.00 | 44,670,603.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,791,682.00 | 2,892,449.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,876,704.00 | 40,470,144.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,162,120.00 | 1,308,010.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 48,841,633.00 | 32,987,549.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,117,225.00 | 8,375,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,991,570.00 | 19,058,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 689,538.00 | 627,929.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,393,300.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 18,792,600.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,857,400.00 | 4,925,220.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,055,800.00 | 6,205,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,890,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 3,165,800.00 | 6,205,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,528,500.00 | 15,450,000.00 |



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 3,528,500.00 | 15,450,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,286,649.00 | 9,502,549.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,841,500.00 | 7,650,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 216,600.00 | 159,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 211,749.00 | 211,749.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 873,000.00 | 360,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 451,000.00 | 451,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 181,416,150.00 | 54,945,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 23,968,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 181,416,150.00 | 30,977,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,791,655,271.00 | 3,589,004,028.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,653,112,112.00 | 3,406,529,134.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 886,487,146.00 | 996,818,751.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 756,084,966.00 | 2,408,910,383.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,540,000.00 | 800,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 138,543,159.00 | 182,474,894.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 138,543,159.00 | 182,474,894.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 40,680,000.00 | 32,100,000.00 |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 40,680,000.00 | 32,100,000.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | 40,680,000.00 | 32,100,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 40,680,000.00 | 32,100,000.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 40,680,000.00 | 32,100,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 40,680,000.00 | 32,100,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | -40,680,000.00 | -32,100,000.00 |

20
УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөг/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 612,287,721.25 | 220,155,972.49 | -254,514,404.84 | 577,929,288.90 | |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 243,981.52 | 243,981.52 | |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 612,287,721.25 | 220,155,972.49 | -254,270,423.32 | 578,173,270.42 | |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | -243,981.52 | | -243,981.52 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 9,804,842.21 | 9,804,842.21 | |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 612,287,721.25 | 219,911,990.97 | -244,465,581.11 | 587,734,131.11 | |
| D01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 612,287,721.25 | 219,911,990.97 | -244,465,581.11 | 587,734,131.11 | |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 398,840.21 | 398,840.21 | |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 612,287,721.25 | 219,911,990.97 | -244,066,740.9 | 588,132,971.32 | |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -398,840.21 | | -398,840.21 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | | | | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | **Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | | 1,535,052.49 | 1,535,052.49 | |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 612,287,721.25 | 219,513,150.76 | -242,531,688.41 | 589,269,183.60 | |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| ЭЗА | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Тайлант оны Гүйцэтгэл | Тайлант оны Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 4,082,512,200.00 | 3,900,037,306.00 | 182,474,894.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 4,082,512,200.00 | 3,900,037,306.00 | 182,474,894.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 587,033,400.00 | 493,508,172.00 | 93,525,228.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 357,113,300.00 | 319,448,769.00 | 37,664,531.00 |
| 210101 | Үндсэн цалин | 218,035,300.00 | 203,722,635.00 | 14,312,665.00 |
| 210102 | Нэмэгдэл | 71,422,700.00 | 57,890,882.00 | 13,531,818.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 31,944,000.00 | 36,503,000.00 | -4,559,000.00 |
| 210104 | Урамшуулал | 35,711,300.00 | 21,332,252.00 | 14,379,048.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,639,100.00 | 39,470,752.00 | 5,168,348.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,354,600.00 | 27,153,156.28 | 3,201,443.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,571,100.00 | 3,194,487.69 | 376,612.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,856,900.00 | 2,555,590.12 | 301,309.88 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 714,200.00 | 592,561.22 | 121,638.78 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,142,300.00 | 5,974,956.69 | 1,176,343.31 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 47,504,800.00 | 44,670,603.00 | 2,834,197.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,638,700.00 | 2,892,449.00 | -253,749.00 |
| 210302 | Түлш, халаалт | 42,900,500.00 | 40,470,144.00 | 2,430,356.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,965,600.00 | 1,308,010.00 | 657,590.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,022,700.00 | 23,057,599.00 | 9,965,101.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,567,500.00 | 3,510,700.00 | 56,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,319,400.00 | 14,593,750.00 | -274,350.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,416,200.00 | 627,929.00 | 9,788,271.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 175,200.00 | | 175,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 219,000.00 | | 219,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,325,400.00 | 4,325,220.00 | 180.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 72,103,600.00 | 37,495,200.00 | 34,608,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 66,708,400.00 | 32,100,000.00 | 34,608,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,395,200.00 | 5,395,200.00 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,172,700.00 | 4,006,000.00 | 166,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,172,700.00 | 4,006,000.00 | 166,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,076,800.00 | 9,502,549.00 | 1,574,251. |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,227,000.00 | 7,650,000.00 | 577,000 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 608,500.00 | 604,800.00 | 3,700.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 182,000.00 | 159,000.00 | 23,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 212,300.00 | 211,749.00 | 551.00 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 90,000.00 | 66,000.00 | 24,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,302,000.00 | 360,000.00 | 942,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 455,000.00 | 451,000.00 | 4,000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,400,400.00 | 15,856,700.00 | 1,543,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,288,700.00 | 8,168,500.00 | 1,120,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,111,700.00 | 7,688,200.00 | 423,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,495,478,800.00 | 3,406,529,134.00 | 88,949,666.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,495,478,800.00 | 3,406,529,134.00 | 88,949,666.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,048,903,100.00 | 996,818,751.00 | 52,084,349.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 2,445,775,700.00 | 2,408,910,383.00 | 36,865,317.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 800,000.00 | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,082,512,200.00 | 3,900,037,306.00 | 182,474,894.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 4,082,512,200.00 | 3,900,037,306.00 | 182,474,894.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,082,512,200.00 | 3,900,037,306.00 | 182,474,894.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 21 | 21 | |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15 | 15 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 | |
| 620004 | Гэрээт ажилтан | | | |

**Нэмэлт төсвийн гүйцэтгэл**

**/төгрөг/**

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | 61,272,950.00 | -61,272,950.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 61,272,950.00 | -61,272,950.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 61,272,950.00 | -61,272,950.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 9,929,950.00 | -9,929,950.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 4,865,000.00 | -4,865,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 4,464,950.00 | -4,464,950.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 600,000.00 | -600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 810,000.00 | -810,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 810,000.00 | -810,000.00 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 11,444,000.00 | -11,444,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 11,444,000.00 | -11,444,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 39,089,000.00 | -39,089,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 15,800,000.00 | -15,800,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 23,289,000.00 | -23,289,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 61,272,950.00 | -61,272,950.00 |
| **1311** | **НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | 61,272,950.00 | -61,272,950.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 58,962,950.00 | -58,962,950.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 2,310,000 | -2,310,000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар Хүн бүрд чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх, таван настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах, ясли, хүүхэд харах үйлчилгээг хэрэгжүүлэх, багшийн ёс зүй, нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, эрүүл мэнд, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн “Чадварлаг багш” арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, “Насан туршийн боловсролын төв”-ийн сургалтын чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулж, тусгай хэрэгцээт сургалтын орчинг бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулдаг байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

- ✓ Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгал болон татварын тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлэн мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 6 дугаарын сарын 02-ны өдрийн 120 дугаар "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаалд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,535.1 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 14,252.5 | 11,693.9 | -2,558.6 |
| Үндсэн хөрөнгө | 573,481.6 | 577,575.3 | 4,093.7 |
| **Нийт хөрөнгө** | **587,734.1** | **589,269.2** | **1,535.1** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 587,734.1 | 577,575.3 | 1,535.1 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **587,734.1** | **589,269.2** | **1,535.1** |

Бараа материалын дансны үлдэгдэл 11,693.9 мянган төгрөг болж 2,558.6 мянган төгрөгөөр буурсан нь ашиглалтын хугацаанд эвдэрч хэмхэрч шаардлага хангахгүй болсон бараа материалыг устгаж данснаас хассанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 577,575.3 мянган төгрөг болж 4,093.7 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь 15,368.3 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг акталж, 4,060.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн балансаас балансад шилжүүлж, 32,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг төсвийн хөрөнгөөр бэлтгэж, балансаас балансад 9,950.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг шилжүүлж авсантай холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 577,575.3 мянган төгрөг болж 1,535.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн тайлант үеийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 497,495.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 3,682,130.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 4,179,625.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна. 2022 оны төсвийн төслийг 3,682,130.7 мянган төгрөгөөр нэмсэн нь сургууль, цэцэрлэгийн багш ажилтны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж болон 5 жилд нэг удаа олгох хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг аймгуудын боловсрол, шинжлэх ухааны газраар дамжуулан олгодог болсонтой холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор 97,113.6 мянган төгрөгөөр бууруулан Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,082,512.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,082,512.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,900,037.3 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 93,391.9 мянга, бусад үйл ажиллагаанаас 89,083.0 мянган төгрөгийг тус бүр дутуу зарцуулсан 182,474.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71801- Сургуулийн өмнөх боловсрол, 80802-ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал дэмжлэг | 655,046.6 | 628,248.7 | 26,797.9 | 95.9 |
| 2 | 71802-Ерөнхий боловсрол, 80802-ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал дэмжлэг | 2,839,632.2 | 2,777,480.4 | 62,151.8 | 97.8 |
| 3 | 71808-Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага, 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 579,800.1 | 486,408.1 | 93,391.9 | 83.9 |

УВС АЙМАГ ДАХЬ ТОРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | 71808-Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага, 80802-ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал дэмжлэг | 800.0 | 800.0 | 0.00 | 100 |
| 5 | 71808-Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага, 81845-Хүүхэд хөгжлийн хөтөлбөр | 7,233.3 | 7,100.0 | 133.3 | 98.2 |

Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 37,664.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 5,168.3 мянга, байршилтай холбоотой тогтмол зардлаас 2,834.2 мянга, хангамж бараа материалын зардлаас 9,965.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардлаас 34,608.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр зардлаас 1,574.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 1,543.7 мянга, урсгал шилжүүлгээс 88,949.7 мянган төгрөг, нийт 182,474.9 мянган төгрөгийн хэмнэлт гарсан нь Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн, хяналт тавьж ажилласантай холбоотой байна.
Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Боловсрол, шинжлэх ухааны газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 58,963.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,310.0 мянган төгрөгийн орлогыг тус бүр зарцуулах эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 71808-Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага 80101-Үндсэн үйл ажиллагаа | 2022 он | 100% | 100% | 61,273.0 | 61,273.0 |

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Боловсрол, шинжлэх ухааны газар нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 10,207.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,313,616.2 мянган төгрөгийн 1 хувь буюу 21,568.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 17,254.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсрол, шинжлэх ухааны газар нь хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтад "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг зөрчин эрх бүхүй албан тушаалтны шийдвэргүйгээр 949.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗ

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт**

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг цаашид хэрэгжүүлэн ажиллах.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 949.8 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Мөнгөн урамшуулалтай холбоотой асуудал**

*1.1. Илрүүлэлт:*

Боловсрол, шинжлэх ухааны газрын даргад эрх бүхүй албан тушаалтны шийдвэргүйгээр 1, 2, 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалд 949 839 төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтад "Хуульд нийцээгүй шийдвэр гаргах", 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "албаны эрх мэдлээ хэтрүүлэх",Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтад "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын" 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно, 1.2.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид", 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2023 оны 03 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалт ны тоо | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй | 1 | 949.8 | 0.00 | 0.00 | 0 | 0.00 | 1 | 949.8 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 1 | 949.8 | 0.00 | 0.00 | 0 | 0.00 | 1 | 949.8 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Р.АЮУШ/

2022 оны 02 сарын 15-ны өдөр

20
УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ